



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 07 өдөр

Дугаар Б/47

Хэрлэн сум

Бүтэц орон тоог
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.21, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.12, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 47 дугаар тогтоол, 2021 оны 377 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хороог Монгол улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд байгуулсантай холбогдуулан Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний Биеийн тамир, спортын газрын бүтцийг шинэчлэн баталсугай.

2.Биеийн тамир, спортын газрын бүтцийг 1-р хавсралтаар, албан тушаалын ангилал, зэрэглэл, орон тооны хязгаарыг 2-р хавсралтаар тус тус баталсугай.

3.Батлагдсан бүтцийн дагуу ажилтан, албан хаагчдыг томилох, байгууллагын дотоод журам, албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн мөрдөж ажиллахыг Биеийн тамир, спортын газар (Г.Нэргүйбаатар)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Н.Зоригтбаатар)-т үүрэг болгосугай.


5.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны Б33 тоот захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ

201011152

ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН БҮТЭЦ



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН АЛБАН ТУШААЛЫН АНГИЛАЛ, ЗЭРЭГЛЭЛ
ОРОН ТООНЫ ХЯЗГААР

№	Албан тушаал	Ангилал, зэрэглэл	Орон тоо
1	Дарга	T3-4	1
2	Биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах спортын сургалт дасгалжуулагчийн албаны дарга	T3-6	1
3	Тогтоол шийдвэр, тайлан мэдээ, хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн	T3-8	1
4	Биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилт, арга хэмжээний зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн	T3-9	1
5	Өсвөр үе, залуучууд ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, аж ахуй нэгж байгууллагын биеийн тамир, спорт хариуцсан мэргэжилтэн	T3-9	1
6	Бие бялдрын түвшин тогтоох сорил, бүртгэл мэдээлэл, сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн	T3-9	1
7	Ерөнхий нягтлан бодогч	TY-8	1
8	Архив, бичиг хэргийн эрхлэгч	TY-5	1
9	Ахлах дасгалжуулагч	TYCB-5	2
10	Үндэсний спорт, үндэсний чадам хариуцсан мэргэжилтэн	TYCB-4	1
11	Мэдээллийн цахим сан, статистик хариуцсан мэргэжилтэн	TYCB-4	1
12	Сумд хариуцсан биеийн тамирын арга зүйч	TYCB-4	2
13	Нярав	TY-4	1
14	Жолооч	TY-3	1
15	Сантехникч, цахилгаанчин	TY-2	1
16	Үйлчлэгч	TY-1	4
17	Жижүүр	TY-1	4
18	Гэрээт ажилтан	TY-1	2